



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2023 оны 09 сарын 26-ны  
өдрийн 6431 дугаарт бүртгэв.

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/177

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих  
нэмэлт шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан "Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих мэргэжилтэй хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг илтгэх нэмэлт шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/101 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Бүртгэлийн дугаар 511  
МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуульбар олгосон ажилтны гарын үсэг  
Дамтшаа  
2023 оны 08 сарын 21-ний өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2023 оны 06 дугаар сарын 28-ны  
өдрийн 1177 тоот тушаалын  
хавсралт



### ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ЭТГЭЭДЭД ТАВИХ МЭРГЭЖИЛТЭЙ ХҮНИЙ НӨӨЦ,  
ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ ИЛТГЭХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ  
2023



**НЭГ. Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага**

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
5.2.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	Авто замын инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 8 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</li> </ul>
	Гүүрийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 6 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</li> </ul>
	Хэмжилтийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 1 жил нь замын зураг төслийн чиглэлээр ажилласан авто замын инженер эсвэл геодезийн инженер байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> </ul>
	Инженер-эдийн засагч-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. (Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно).</li> <li>- Эдийн засагч нь дадлага, туршлагатай гэрээт ажилтан байж болно.</li> </ul>
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх.
Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл хүссэн тохиолдолд инженер техникийн ажилчдын 70-аас доошгүй хувь нь дотоодын инженер, техникийн ажиллагсад байна.		


МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН Хөгжлийн ЯАМ

**ЭХ ХУВЬ**

Сайд Т.Оршумбаа  
дэргэц 2023.07.17-ийн тушаал


**ХОЁР. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага**

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
5.2.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах	Авто замын инженер-2	<ul style="list-style-type: none"> <li>- Аль нэг авто замын инженер нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 8 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Аль нэг авто замын инженер нь зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</li> <li>- Аль нэг инженер нь гадаадын иргэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай авто замын инженер байж болно.</li> </ul>
	Гүүрийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 8 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх.</li> <li>- Гүүрийн инженер нь гадаадын иргэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан инженер байж болно.</li> </ul>
	Хэмжилтийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3 жил нь замын зураг төслийн чиглэлээр ажилласан авто замын инженер эсвэл геодезийн инженер байх шаардлагатай.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Гадаадын иргэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан авто замын инженер эсвэл геодезийн инженер байж болно.</li> </ul>
	Материалын инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 8 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Энэ чиглэлээр мэргэшсэн авто замын инженер байж болно.</li> </ul>
	Төсөвчин-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, Авто замын мэргэшсэн төсөвчин байна.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> </ul>
	Зургийн техникч - 3	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төслийн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> </ul>
Шаардлагатай тоног төхөөрөмж		Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх.




ГУРАВ. Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл хүсээгч этгээдэд тавих нэмэлт шаардлага

Д/Д	Нэрс ба хүчин чадал	5.2.3.1. Авто зам барих	5.2.3.2. Замын байгууламж барих	5.2.3.3. Авто зам, замын байгууламжийг засварлах	5.2.3.4. Авто зам, замын байгууламжийг арчлах
		Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто замыг барих (Их засвар, шинэчлэлт)	Бүх төрлийн замын байгууламжийг барих (Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам барих)	Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто зам, замын байгууламж, түүний ээлжит болон урсгал засвар	Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, талбайн тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажил
A.		<b>Технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор (Хамгийн багадаа)</b>			
1	Экскватор /0.65м³/	2 (1 нь түрээс байж болно)	1	1	
2	Автогрейдер /250м.х/	1		1	1(Түрээс байж болно)
3	Ачигч /1.0м³/	2	1	1	1
4	Доргиурт индүү /16 тн-оос дээш/	2 (1 нь түрээс байж болно)	1		1(Түрээс байж болно)
5	Хийн дугуйт индүү /10 тн/	1		1	
6	Асфальтны индүү /6тн-оос дээш	1		1	1
7	Автогудронатор /3.5 м/	1		1	
8	Өөрөө буулгагч	6 (3 нь түрээс байж болно)	2	2	1
1	Усны машин	2	1	1	1(Түрээс байж болно)
10	Асфальт дэвсэгч	1 (Түрээс байж болно)		1(Түрээс байж болно)	
11	Авто кран /25 тн-үүс дээш/		2 (1 нь түрээс байж болно)		
12	Шигшүүртэй чулуу бутлуур	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)		
13	Асфальтобетон завод /80 тн/цаг/	1 (Түрээс байж болно)		1 бага оврын (Түрээс байж болно)	
14	Лаборатори /иж бүрэн/	1	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)
15	Геодезийн иж бүрдэл	1	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)
16	Бетон узель	1	1	1 (Түрээс байж болно)	
17	Тэмдэглэгээний машин, тоног төхөөрөмж			1	1
18	Авто замын				1



	арчлалтын цас цэвэрлэгч машин				
Түрээслэн ажиллуулах машин, механизмын түрээсийн гэрээ нь тусгай зөвшөөрлийн хугацаанд хүчин төгөлдөр байх.					
<b>Мэргэжлийн инженер техникийн ажилтны хамгийн бага тоогоор</b>					
18	Ерөнхий инженер	1	1	1	
19	Авто замын инженер	2*	1	1	1
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	1	2*		
21	Геодезийн инженер	1	1		
22	Материалын инженер	1	1	1	1
<b>Б. Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>					
1.	Нэмэлт тайлбар: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженерээр тооцож болно. Авто замын инженерийг гүүрийн барилгын ажлын туршлагыг үндэслэн гүүрийн инженерт тооцож болно. Зөвлөх инженерийн зэрэгтэй ажилтан нь үндсэн ажилтан биш тохиолдолд гэрээт ажилтан байж болно. Зөвлөх инженер нь 3 хүртэлх байгууллагад зөвлөж болно. * Аль нэг нь гэрээт байж болно.	Ерөнхий инженер нь 8 жил ажилласан ажлын туршлагатай зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх. Авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн зэрэгтэй байх, бусад инженерүүд ажлын 3-5 жилийн туршлагатай байх.	Ерөнхий инженер нь 8 жил ажилласан ажлын туршлагатай зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх. Гүүр, хиймэл байгууламж, авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн зэрэгтэй байх, бусад инженерүүд ажлын 3-5 жилийн туршлагатай байх.	Ерөнхий инженер нь 5 жил ажилласан, авто замын барилгын ажлын туршлагатай, бусад инженерүүд ажлын туршлагатай байх.	Авто замын инженер нь 3 жил ажилласан туршлагатай, авто замын бусад инженерүүд ажлын туршлагатай байх.



**ДӨРӨВ. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл хүсээгч этгээдэд тавих нэмэлт шаардлага**

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
5.2.4. Авто зам, замын байгууламжийг барих, засварлахад техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Ерөнхий инженер	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 8 жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Хяналтын инженерийн тэргүүн зэрэгтэй, зөвлөх эсвэл мэргэшсэн инженер байх.</li> </ul>
	Замын инженер-2	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил нь тухайн чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Аль нэг инженер нь мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.</li> </ul>
	Гүүрийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил нь тухайн чиглэлээр ажилласан байх гүүрийн инженер мэргэжилтэй, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> </ul>
	Материалын инженер-2	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил нь тухайн чиглэлээр ажилласан зам, гүүрийн инженер мэргэжилтэй, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженер байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> </ul>
	Тоо хэмжээний инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил нь хяналтын чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Зам, гүүрийн инженер мэргэжилтэй, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженер байх.</li> </ul>

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ХОГАЛРИН НАМ

**ЭХ ХУБЬ**

Саяд 2023 оны 07 сарын 14 өдөр  
дэргэд 2023/07/14

	Хэмжилтийн инженер-1	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтын чиглэлээр ажилласан байх.</li> <li>- Байгууллагын үндсэн ажилтнаар нийгмийн даатгал төлсөн байх /НД-7, НД-8 сүүлийн 3 сар/.</li> <li>- Зам, гүүрийн инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл геодезийн инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.</li> </ul>
Шаардлагатай тоног төхөөрөмж		Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх.

---oO---

МОНГОЛ УЛСЫН  
 ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
 ЭХ ХУВЬ  
 Сайд Төрийн үйлчилгээний бичгийн  
 дарга *2023.07.17* *А.Булдур* Гүшгэдл